



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь: “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000 м.куб бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий байгууламжийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн протокол, зээлийн гэрээний дагуу хэрэгжүүлсэн “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд шинээр баригдсан хоногт 24000 м.куб бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий байгууламжийн өргөтгөлийг хүлээн авах Улсын комиссыг ажиллуулж, байнгын ашиглалтад хүлээн авах асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлүүлэх;
2. Цэвэрлэх байгууламжийн ашиглагч байгууллагаар “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг сонгосны дагуу ашиглалт, үйлчилгээг үргэлжлүүлэн хариуцах;
3. Цэвэрлэх байгууламжийн зээлийн эргэн төлөлтийн асуудлыг дамжуулан зээлдүүлэх гэрээний хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002002

\Huraldaanii material\2021 on\2021.09.24 15-r huraldaan.docx